

МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

___ оны ___ сарын ___ өдөр

Дугаар ___

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Дархлаажуулалтын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсэг, 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсэг, 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Дархлаажуулалтын дараах урвал, хүндрэлийг тандах журмыг нэгдүгээр, Дархлаажуулалтын дараах урвал, хүндрэлийн ангиллыг хоёрдугаар, Сэргийлэх тарилга хийхэд харшлах өвчин эмгэгийн жагсаалтыг гуравдугаар, Дархлаажуулалтын дараах урвал, хүндрэл бүртгэгдсэн үед хэрэгжүүлэх эрсдэлийн харилцаа холбооны удирдамжийг дөрөвдүгээр, Дархлаажуулалтын дараах урвал, хүндрэлийн бүртгэлийн хуудсыг тавдугаар, Дархлаажуулалтын дараах урвал, хүндрэлийн судалгааны хуудсыг зургаадугаар, Дархлаажуулалтын дараах урвал, хүндрэлийн сарын мэдээний нэгдсэн бүртгэлийг долоодугаар, Дархлаажуулалтын дараах урвал, хүндрэлийн үед лабораторийн шинжилгээнд сорьц авах зааврыг наймдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү тушаалыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахыг Халдварт өвчин судлалын үндэсний төв (С.Энхболд), аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, бүх шатны эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийн газар (Б.Цэцэгсайхан)-т даалгасугай.

4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2012 оны 217 дугаар тушаал, Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 261 дүгээр тушаал, Эрүүл мэнд, спортын сайдын 2016 оны А/278 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

Э.БАТШУГАР

**ДАРХЛААЖУУЛАЛТЫН ДАРААХ УРВАЛ,
ХҮНДРЭЛ (ДДУХ)-ИЙГ ТАНДАХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг зүйл

- 1.1. Энэхүү журмыг өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллага дархлаажуулалтын дараа илэрч болох урвал, хүндрэлээс сэргийлэх, илрүүлэх, бүртгэх, мэдээлэх, тандан судлах, дүн шинжилгээ хийх, хариу арга хэмжээ авах үйл ажиллагаанд мөрдөнө.

Хоёр. Сум, өрхийн эрүүл мэндийн төвийн эмч, эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагын нярайн болон хүүхдийн эмч нарын гүйцэтгэх үүрэг

Дархлаажуулалтын өмнө эмчийн үзлэг хийх нь хүүхдийн биеийн байдлыг үнэлж, вакцин хийхэд харшлах өвчин, эмгэг байгаа эсэхийг тогтоож, дархлаажуулалтын дараах урвал, хүндрэлээс сэргийлэх зорилготой.

- 2.1. Хүүхдэд дархлаажуулалт хийх тохиолдол бүрийн өмнө үзлэг хийнэ. (O2 сатураци, даралт судасны цохилт, хэлний өнгөр, нүдний салст, залгиур хоолой, нүцгэн биеийн үзлэг). Үзлэгийг амаржих газарт нярайн эмч, 2 сартайгаас дээш насны хүүхдэд сум, өрх, дүүргийн эрүүл мэндийн төвийн эмч хийнэ. Эхийн жирэмслэлт, төрөлтийн явц, удмын байдал, хүүхдийн бие сэтгэцийн өсөлт, өвчилж байсан өвчин, урьд нь вакцин тариулсны дараа урвал хүндрэл илэрч байсан эсэхийг судална.
- 2.2. Мэдрэлийн талаас эмгэгтэй, амьсгалын замын болон бусад өвчнөөр байнга өвчилдөг, урьд нь дархлаажуулсны дараа хариу урвал, хүндрэл илэрч байсан, өндөг болон ямар нэгэн эмийн зүйл хэрэглэсний дараа харшил илэрч байсан хүүхдийг дархлаажуулах асуудлыг шийдвэрлэнэ.
- 2.3. Шаардлагатай тохиолдолд холбогдох мэргэжлийн эмчид үзүүлж хамтран зөвлөлдөж дархлаажуулалтад хамрагдах эсэх, тухайн хүүхдэд тохирсон товллол гаргаж, эх хүүхдийн эрүүл мэндийн дэвтэрт тэмдэглэл хийнэ.
- 2.4. Тарилга хийх тухайн өдөр эмчийн үзлэгт хамрагдсан байх ёстой ба өмнөх өдрийн үзлэгээр дархлаажуулалт хийхгүй.
- 2.5. Эмчийн үзлэгээр эсрэг заалтгүй, хурц халдварт өвчингүй хүүхдийг вакцинд хамруулах бөгөөд тухайн өдөр ямар вакцины хэд дэх тунд хамрагдах талаар тодорхой бичиж нярайн түүх болон эх хүүхдийн эрүүл мэндийн дэвтэрт тэмдэглэнэ. Сум, өрх, багийн эмч нар нярайн гэрийн эргэлтээр биеийн байдлыг үнэлэхээс гадна БЦЖ вакцины сорвижилтыг 1, 3, 12 сартайд хянаж, хүүхдийн урьдчилан сэргийлэх тарилгын гэрчилгээнд тэмдэглэл хөтөлнө.
- 2.6. Хүүхдийг 7, 11, 15 настайд товллолын дагуу сахуу, татран, хүний папиллома вирусийн эсрэг вакциныг хийхдээ ерөнхий боловсролын сургуулийн эмч, багш,

эрүүл мэндийн ажилтнаар дамжуулан эцэг, эх, асран хамгаалагч нарт мэдээлэл хүргэж, тарилга хийхийн өмнө хүүхэд бүрд эмчийн үзлэг хийж, харшлах өвчин, эмгэггүй хүүхдийг дархлаажуулна.

- 2.7. Тухайн хүүхдийг дархлаажуулсан талаар эх хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр, нярайн түүхэнд тэмдэглэл хийн, дархлаажуулалтын цахим бүртгэлийн програмд шивж оруулна.
- 2.8. ДДУХ-ийн тохиолдол илэрвэл өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн эмч харьяа аймаг, дүүргийн дархлаажуулалт хариуцсан мэргэжилтэнд, нийслэлийн харьяа амаржих газрын дархлаажуулалт хариуцсан халдвар судлагч эмч нь Нийслэлийн эрүүл мэндийн газрын дархлаажуулалт хариуцсан мэргэжилтэнд, лавлагаа шатлалын эмнэлэг, хувийн хэвшлийн эмнэлгийн эмч нар Халдварт өвчин судлалын үндэсний төвийн ДДУХ аюулгүй дархлаажуулалт хариуцсан эмчид холбогдох тушаалын дагуу 24 цагийн дотор утсаар болон immunization@nccd.gov.mn цахим хаягаар мэдээлнэ.
- 2.9. ДДУХ илэрсэн үед яаралтай тусламж үзүүлж, шаардлагатай тохиолдолд эмнэлэгт хэвтүүлэн эмчлэх арга хэмжээг шуурхай зохион байгуулна.
- 2.10. ДДУХ-ийн тохиолдол бүрийг Дархлаажуулалтын дараах урвал, хүндрэлийн бүртгэлийн хуудасны дагуу бүртгэнэ.
- 2.11. Нярайн болон хүүхдийн эмч нь ноцтой хүнд ДДУХ, нас барсан, тахир дутуу болсон, эмнэлэгт хэвтсэн, багц тохиолдол бүрийг зургаадугаар хавсралтын дагуу судалгаа хийж, нэг хувийг харьяа аймаг, нийслэл, дүүрэг, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн ДДУХ, аюулгүй дархлаажуулалт хариуцсан эмчид илгээж, хоёр дахь хувийг байгууллага дээрээ хадгална.
- 2.12. ДДУХ илэрсэн шаардлагатай тохиолдолд харьяа аймаг, дүүргийн эмчилгээний чанарын улсын байцаагчид мэдээлж, наймдугаар хавсралтад заасан зааврын дагуу вакцин, уусгагч, зүү тариураас дээж авч шинжлүүлэн, шинжилгээний хариуг Халдварт өвчин судлалын үндэсний төвд ирүүлнэ. Шинжилгээний зардлыг дархлаажуулалт хийсэн эрүүл мэндийн байгууллага хариуцна.
- 2.13. ДДУХ-ийн сарын мэдээг наймдугаар хавсралтын дагуу гарган, заавал хийх дархлаажуулалтын хамралтын сарын мэдээний хамт харьяа аймаг, дүүрэг, нийслэлийн дархлаажуулалт хариуцсан мэргэжилтэнд цаасаар болон цахимаар ирүүлнэ.
- 2.14. ДДУХ-ийн тохиолдол бүртгэгдсэн тухайн сум, орон нутагт идэвхтэй тандалт хийж хариу арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
- 2.15. Дархлаажуулалтын дараа гарч болох урвал, хүндрэлийн талаар эцэг, эхчүүдэд мэдээлэл өгч, илэрсэн тохиолдолд нэн даруй эмнэлэгт хандах талаар зөвлөгөө өгнө.

Гурав. Аймаг, нийслэл, дүүргийн дархлаажуулалт хариуцсан мэргэжилтний гүйцэтгэх үүрэг

- 3.1. Аймаг, нийслэл, дүүргийн хэмжээнд ДДУХ-ээс сэргийлэх болон ДДУХ бүртгэгдсэн тохиолдолд тандалтыг зохион байгуулж, мэргэжил, арга зүйн зөвлөмжөөр ханган, холбогдох арга хэмжээг шуурхай зохион байгуулна.

- 3.2. Энэ журмын 2.9-д заасан мэдээллийг хүлээн авсан дүүргийн дархлаажуулалт хариуцсан мэргэжилтэн нь нийслэлийн эрүүл мэндийн газарт, аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар нь Халдварт өвчин судлалын үндэсний төв (ХӨСҮТ)-ийн Дархлаажуулалтын албаны ДДУХ, аюулгүй дархлаажуулалт хариуцсан эмчид утсаар болон immunization@nccd.gov.mn цахим хаягаар 24 цагийн дотор яаралтай мэдээлнэ.
- 3.3. ДДУХ-ийн ноцтой хүнд ДДУХ, нас барсан, тахир дутуу болсон, эмнэлэгт хэвтсэн, багц тохиолдол бүрд зургаадугаар хавсралтын дагуу судалгаа хийж, нэг хувийг тухайн дархлаажуулалтын дараах урвал, хүндрэл илэрсэн нэгжид, хоёр дах хувийг ХӨСҮТ-ийн Дархлаажуулалтын албанд, гурав дах хувийг Аймаг, Нийслэлийн эрүүл мэндийн газар, дүүргийн эрүүл мэндийн төвийн архивт хадгалуулна.
- 3.4. Аймаг, дүүргийн дархлаажуулалт хариуцсан мэргэжилтэн мэдээлэгдсэн тоо мэдээнд дүн шинжилгээ хийж хоёрдугаар хавсралт дагуу тухайн вакцины зааварт тусгагдсан хариу урвалууд илрэх түвшинд байгаа эсэхэд хяналт тавина.
- 3.5. ДДУХ-ийн илрэх түвшинд илэрсэн бол ДДУХ-ийн талаарх ташаа, хэт дэврүүлсэн мэдээллийн эсрэг залруулах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
- 3.6. ДДУХ-ийн тохиолдлын мэдээ авмагц аймгийн Эрүүл мэндийн газар, дүүргийн Эрүүл мэндийн төвийн дарга нь ДДУХ-ийн мэргэжлийн баг (дархлаажуулалт хариуцсан их эмчээр ахлуулсан, хүүхдийн зохицуулах мэргэжилтэн, мэдрэлийн эмч, чанарын менежер, нян судлал, клиник лабораторийн эмч, мэс заслын эмч гэх мэт бусад эмчийн бүрэлдэхүүнтэй)- ийг томилон ажиллуулна.
- 3.7. Мэргэжлийн баг нь тухайн ДДУХ-тэй холбоотой мэдээллийг системтэйгээр үнэлж, тухайн үйл явдал нь хийлгэсэн вакцин(ууд)-аас үүдэлтэй байх шалтгаан хамаарал, магадлалыг тодорхойлно.
- 3.8. Мэргэжлийн баг нь ДДУХ-ийн тохиолдлын шалтгааныг тогтоох зорилгоор дархлаажуулалттай холбоотой бүх үйл ажиллагааг хянаж нарийвчилсан судалгааг ажлын 3 хоногт багтаан эхний дүгнэлтийг гарган, харъяа аймаг, дүүрэг, нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын эмчилгээний чанарын хяналтын байцаагчид хүргүүлж, ДДУХ-ийн сэжигтэй тохиолдлыг магадлан тогтоолгоно.
- 3.9. Мэргэжлийн баг нь ДДУХ-ийн тохиолдлын биеийн байдлыг үнэлж, сэжигтэй өвчтөнг шаардлагатай тохиолдолд дараагийн шатны эмнэлэгт шилжүүлэх асуудлыг яаралтай шийдвэрлэнэ.
- 3.10. Шаардлагатай тохиолдолд вакцин, зүү тариурын сорьц, өвчтөнөөс авсан шинжлэгдэхүүнд лабораторийн шинжилгээ хийлгэж, шинжилгээний хариуг албан ёсоор Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Дархлаажуулалтын албанд хүргүүлнэ. Шинжилгээний зардлыг дархлаажуулалт хийсэн эрүүл мэндийн байгууллага хариуцна.
- 3.11. Цаг хугацаа, газар зүйн ижил байрлалд нэг төрлийн вакцин тариулсан, ижил шинж тэмдэгтэй ДДУХ-ийн тохиолдол байгаа эсэхийг илрүүлэх идэвхтэй тандалтыг (хүүхдийн эмнэлэг, тасагт хэвтэж эмчлүүлж байгаа өвчтөн, өвчний

түүх, үзлэгийн журнал, дуудлагын хуудас, хүлээн авахын бүртгэл) зохион байгуулна.

- 3.12. Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын дархлаажуулалт хариуцсан мэргэжилтэн харьяа эмнэлгүүдээс хүлээн авсан ДДУХ-ийн тохиолдлын сарын мэдээг долоодугаар хавсралтын дагуу гаргаж заавал хийх дархлаажуулалтын хамралтын сарын мэдээний хамт дараа сарын 10-ны дотор ХӨСҮТ-ийн Дархлаажуулалтын албанд цаасаар болон immunization@nccd.gov.mn цахим хаягаар ирүүлнэ.

Дөрөв. Халдварт өвчин судлалын үндэсний төвийн гүйцэтгэх үүрэг

- 4.1. ДДУХ-ийн тандалтыг улсын хэмжээнд зохион байгуулж, мэргэжил, арга зүйн удирдлагаар ханган, холбогдох арга хэмжээг шуурхай зохион байгуулна.
- 4.2. ДДУХ-ийн тохиолдлыг 24 цагийн дотор Эрүүл мэндийн яамны Нийгмийн эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийн газарт мэдээлнэ.
- 4.3. ДДУХ, аюулгүй дархлаажуулалт хариуцсан эмч улсын хэмжээнд мэдээлэгдсэн тоо мэдээнд дүн шинжилгээ хийж, тухайн вакцины зааварт тусгагдсан хариу урвалууд илрэх түвшинд байгаа эсэхэд хяналт тавин сар бүрийн тайлан мэдээг Эрүүл мэндийн яамны Нийгмийн эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийн газарт хүргүүлнэ.
- 4.4. Мэдээ, мэдээлэлд дүн шинжилгээ хийхийн өмнө бүртгэгдсэн тохиолдлууд нь тохиолдлын тодорхойлолтод тохирч байгаа эсэхийг шалгана.
- 4.5. ДДУХ-ийн талаарх ташаа, хэт дэврүүлсэн мэдээллийн эсрэг залруулах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
- 4.6. Тухайн ДДУХ-тэй холбоотой мэдээллийг нарийвчлан үнэлж, тухайн үйл явдал нь хийлгэсэн вакцин(ууд)-аас үүдэлтэй байх магадлалыг тодорхойлоход шаардлагатай мэдээ мэдээллийг цуглуулна.
- 4.7. ДДУХ-ийн тандалтаар илэрсэн багц тохиолдлууд, ноцтой, хүнд хэлбэрийн тохиолдол болон бусад шаардлагатай нөхцөлд Сэргийлэх тарилгын дараах урвал хүндрэлийн шалтгаан хамаарлыг тогтоох хороогоор хэлэлцүүлнэ .
- 4.8. ДДУХ-ийн мэдээллийг нэгтгэн дүн шинжилгээ хийж, Сэргийлэх тарилгын дараах урвал хүндрэлийн шалтгаан хамаарлыг тогтоох хороо болон эмчилгээний чанарын хяналтын байцаагчийн дүгнэлтийг үндэслэн баталгаажуулсны дараа Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газарт мэдээлнэ.
- 4.9. ДДУХ-ээс сэргийлэх, илрүүлэх, мэдээлэх, судлах, тандалт хийх, хариу арга хэмжээ авах талаар дархлаажуулалтыг зохион байгуулдаг өмчийн бүх хэлбэрийн эмнэлгийн нярайн болон хүүхдийн эмч нар, сум, өрхийн эмч, дархлаажуулалт хариуцсан халдвар судлагч нар, сувилагч нарт сургалт зохион байгуулна.
- 4.10. ДДУХ-ийн тандалт, хариу арга хэмжээний талаар эрүүл мэндийн байгууллагуудад хагас бүтэн жилээр эргэн мэдээллээр ханган ажиллана.

Тав. Эм эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газар

- 5.1. Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ)-ын эмийн олон улсын хяналтын хөтөлбөрийг хэрэгжүүлэгч Уппсала төвийн гаж нөлөө бүртгэх үндэсний мэдээний сан Вижифлоу (Vigiflow), дохио илрүүлэх, олон улсад мэдээлэл солилцох Вижилайз (Vigilyze) системүүдэд ХӨСҮТ-өөс хүлээн авсан мэдээг сар бүр мэдээлж, эмийн гаж нөлөөний мэдээний санг хөтлөх үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.
- 5.2. ХӨСҮТ-ийн Дархлаажуулалтын албанд олон улсад мэдээлэл солилцох Вижилайс (Vigilyze) системийн эмийн гаж нөлөөний мэдээг сар бүр илгээж, мэргэжил арга зүйгээр ханган ажиллана.
- 5.3. ДДУХ болон сэжигтэй тохиолдлыг бүртгэн мэдээлэх талаар эрүүл мэндийн байгууллагын эмч мэргэжилтнүүдэд зориулсан сургалтыг Халдварт Өвчин судлалын үндэсний төвтэй хамтран зохион байгуулна.
- 5.4. Төрийн болон эрүүл мэндийн байгууллагыг дархлаажуулалтын дараах урвал, хүндрэлийн талаарх мэдээллээр хангана.

Эрүүл мэндийн сайдын 2026 оны дүгээр сарын өдрийн -р тушаалын хоёрдугаар хавсралт

**ДАРХЛААЖУУЛАЛТЫН ДАРААХ УРВАЛ,
ХҮНДРЭЛИЙН АНГИЛАЛ**

Дархлаажуулалтын дараах урвал гэж вакцинд хамрагдсаны дараа үүссэн, вакцинтай шалтгаан хамааралгүй ч байж болох эмнэлзүйн ямар нэгэн шинж тэмдгийн илрэлийг дархлаажуулалтын дараах урвал гэнэ.

Дархлаажуулалтын дараах урвалыг вакцин тарьсан хэсэг газрын болон ерөнхий урвал гэж ангилна. Ихэнх эмнэлзүйн шинж тэмдгүүд болон илэрч болох хариу урвалууд 1-3 хоногийн дараа өөрөө аяндаа арилдаг.

Дархлаажуулалтын дараах хүндрэл гэж илэрсэн зарим эмнэлзүйн шинж тэмдгүүд тогтвортой үргэлжлэх, эсхүл ноцтой, ховор тохиолдох шинж тэмдгийн илрэлийг хэлнэ.

Дархлаажуулалтын дараах урвал, хүндрэл (ДДУХ)-ийн шалтгааныг дархлаажуулалтын үйл ажиллагааны алдаа, вакцинаас үүдэлтэй эсвэл эрүүл мэндийн эмгэг байдал нь вакцин тарьсан цаг хугацаатай давхцаж илэрсэн, шалтгаан тодорхойгүй гэж ангилан үзнэ.

Гаж тохиолдол нь таамаглагдаагүй тодорхойгүй илрэл лабораторийн өөрчлөлт шинж тэмдэг буюу эмгэгшил байж болно.

Хүснэгт 1. Илэрч болох хариу урвал, тохиолдож болох түвшин, вакцинаар:*

Вакцины дараа гарч болох урвалын түвшин	Илэрч болох урвал, эмнэлзүйн шинж тэмдэгүүд	Вакцин
Маш түгээмэл (давтамж $\geq 1/10$ буюу $\geq 10\%$)	Тарьсан газар улайх, хавдах, өвдөх хөндүүрлэх,	БЦЖ, Гепатит В, ХПВ, Сахуу, хөхүү ханиад, татран (СХТ), Пневмококк, улаанбурхан, гахай хавдар, улаанууд (УГУ), Хижиг (Typhoid ViCPS)
	Бага зэрэг халуурах	Гепатит А, СХТ, хүний папиллома вирус (ХПВ), Салхин цэцэг, Улаанбурхан, Япон энцефалит
	Толгой өвдөх	Гепатит В, ХПВ, Япон энцефалит
	Бие тавгүйрхэх	Гепатит В, ХПВ
	Ходоод гэдсэний хямрал	ХПВ, Япон энцефалит
	Ядрах, сульдах, тайван бус уйлагнах, хоолны дуршил буурах, бөөлжих	Гепатит А, СХТ, Япон энцефалит
	Тууралт гарах	ХПВ, Салхин цэцэг, Улаанбурхан,

		Япон энцефалит
	Булчин өвдөх, үе мөч өвдөх	ХПВ, Япон энцефалит
Түгээмэл (давтамж >1/100 ба <1/10 буюу 1-10%)	Тарьсан газар өвдөх, хөндүүрлэх, тайван бус болох	Гепатит А, СХТ
	Тарьсан газар хөндүүрлэх, хатуурах	Гепатит В, Халдварт саагийн эсрэг тарьдаг вакцин (IPV)
	Арьсан дээр тууралт гарах	Салхин цэцэг, Салхин цэцэг агуулсан УГУ
	Хооллохтой холбоотой хүндрэл үүсэх (хоолонд дургүй болох)	Гепатит В
	Суулгах	Хижиг, Гепатит В
	Дунд зэргийн халуурах	Гепатит А, СХТ
	Цочмог үе мөчний үрэвсэл	Улаанууд
	Чихний доод булчирхай хавдах	Гахай хавдар
	Булчин өвдөх, нус гоожих, бөөлжих <39°C-өөс доош халуурах	Япон энцефалит, Хижиг Хижиг (Typhoid ViCPS)
	Түгээмэл биш (давтамж ≥1/1000 ба <1/100 буюу ≥0.1% ба <1%)	Бие тавгүйрхэж, тарьсан газарт хүчтэй өвдөх
Тарьсан газар хатуурах, бага зэргийн шархлаа үүсэх, сорвижих		БЦЖ
>20 мм-ээс дээш хэмжээтэй хавдах		Гепатит А, СХТ
Тарьсан газар хатуурах		Халдварт саагийн эсрэг тарьдаг вакцин (IPV)
Хэсэг газарт буглаа үүсэх, лимпаденит		БЦЖ
Остит		БЦЖ
Хэт мэдрэгшлийн урвалууд		Япон энцефалит, Хижиг
Хэсэг газрын эритема		Хижиг (Typhoid ViCPS)
Хооллолттой холбоотой асуудал үүснэ (хоолонд дургүй болох)		Гепатит В
Маш ховор (давтамж <1/10 000 буюу <0.01%)	Анафилаксийн шок	Гепатит В, Гепатит А, СХТ, ХПВ, Япон энцефалит, Улаанбурхан
	Тархи, нугасны үрэвсэл	Улаанбурхан, Япон энцефалит
	Асептик менингит	Гахай хавдар
	Дархлаа сэргэхтэй холбоотой үрэвслийн хам шинж	БЦЖ
	Цочмог тархмал тархи нугасны үрэвсэл	Япон энцефалит
	Энцефалит, унах, татах, хөндлөн миелит	Япон энцефалит
	Вакцинтай холбоотой саажилттай полиомиелит	Халдварт саагийн эсрэг уудаг вакцин
	Буглаа	БЦЖ
Тархмал сүрьеэ	БЦЖ	

**-вакциныг дагалдаж буй үйлдвэрлэгчийн зааварт тухайн вакцины дараа илэрч болох урвал, эмнэлзүйн шинж тэмдгийг харах*

Хүснэгт 2. Эрүүл мэндийн байгууллагын шатлал бүрд хийх дүн шинжилгээ ба зорилго

Шатлал	Дүн шинжилгээний төрөл	Зорилго
Анхан шат	<ul style="list-style-type: none"> • Нэгжүүдээс цаг хугацаандаа мэдээгээ ирүүлсэн байдал • Мэдээлэгдсэн ДДУХ-ийн тоо (мэдээлсэн газраар, хүнээр, цаг хугацаагаар) • Мэдээлэгдсэн ДДУХ, үүсгэгчээр 	<ul style="list-style-type: none"> • Цаг хугацаандаа ирүүлсэн байдал болон бүрэн ирүүлсэн байдал зэрэг хөтөлбөрийн хэрэгжилтийн шалгуур үзүүлэлтийг тодорхойлно. • Хөтөлбөрийн алдааг илрүүлж, тэр дор нь залруулах арга хэмжээ авах • Давхацсан эмгэг болон вакцины хариу урвалуудыг тодорхойлно.
Дунд түвшин (аймаг, дүүрэг)	<ul style="list-style-type: none"> • Нийт бүртгэгдсэн ДДУХ • Бүртгэгдсэн ДДУХ-ийг байршил, цаг хугацаа, хүнээр тодорхойлох • ДДУХ багц тохиолдлыг тодорхойлох 	<ul style="list-style-type: none"> • Орон нутгийн түвшинд хөтөлбөрийн хэрэгжилтийн шалгуур үзүүлэлтийг тодорхойлно. • Хөтөлбөрийн алдааг илрүүлэх, залруулах арга хэмжээг газар дээр авах • ДДУХ багц тохиолдолд дүн шинжилгээ хийж хөтөлбөрийн алдааг илрүүлэх, мөн давхацсан эмгэг болон вакцины хариу урвалуудыг илрүүлэх.
Үндэсний түвшин	<ul style="list-style-type: none"> • Аймаг, дүүргээс мэдээлсэн ДДУХ тоо • ДДУХ-ийг байршил, цаг хугацаа, хүнээр дүн шинжилгээ хийх • ДДУХ багц тохиолдолд дүн шинжилгээ хийх • Үүсгэгч буюу эсрэгтөрөгчөөр дүн шинжилгээ хийх 	<ul style="list-style-type: none"> • Аймаг, дүүргийн түвшинд цаг хугацаандаа мэдээг ирүүлсэн байдал болон бүрэн ирүүлсэн байдал зэрэг хөтөлбөрийн хэрэгжилтийн шалгуур үзүүлэлтийг тодорхойлно. • Хөтөлбөрийн алдааг илрүүлэх, залруулах арга хэмжээг газар дээр авах • ДДУХ багц тохиолдолд дүн шинжилгээ хийж хөтөлбөрийн алдааг илрүүлэх, мөн давхацсан эмгэг болон вакцины хариу урвалуудыг илрүүлэх. • Вакцины хариу урвалд дүн шинжилгээ хийх мөн босго үзүүлэлтийг тодорхойлох • Улс орны хэмжээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны болон бодлогын шийдвэрүүдийг гаргах

Эрүүл мэндийн сайдын 2026
оны дүгээр сарын
өдрийн -р тушаалын
гуравдугаар хавсралт

СЭРГИЙЛЭХ ТАРИЛГА (ДАРХЛААЖУУЛАЛТ) ХИЙХЭД ХАРШЛАХ ӨВЧИН ЭМГЭГИЙН ЖАГСААЛТ

2.1 Заавал хийх дархлаажуулалтад харшлах өвчин, эмгэгийн жагсаалт

- Олдмол дархлаа дутмагшил
- Дархлааны төрөлх хомсдол
- Тухайн вакцины найрлагад орсон бодист харшилтай байх
- Тухайн вакцины эсрэг заалтад хамрагдах эмгэгтэй байх
- Өмнө ямар нэгэн вакцин хийлгээд анафилаксийн урвал өгч байсан
- Цочмог өвчний үед, архаг өвчний сэдрэлийн үед эмчилгээний дараа дархлаажуулалтад нөхөн хамруулах

2.2 Сайн дурын дархлаажуулалт хийхэд харшлах өвчин, эмгэгийн жагсаалт

- Дархлааны олдмол хомсдол
- Төрөлхийн дархлаа дутмагшил
- Цусны эсийн хорт хавдар
- Бусад эрхтний хорт хавдрын 3,4 үе
- Зүрх судасны хурц дутмагшил
- Бөөрний хурц дутмагшил
- Цочмог халдварт өвчний ид үе
- Архаг өвчний сэдрэлтийн үе
- Тухайн вакцины найрлагад орсон бодист харшилтай байх
- Тухайн вакцины эсрэг заалтад хамрагдах эмгэгүүд
- Цочмог өвчний үед, архаг өвчний сэдрэлийн үед эмчилгээний дараа дархлаажуулалтад нөхөн хамруулах

ДДУХ БҮРТГЭГДСЭН ҮЕД ХЭРЭГЖҮҮЛЭХ ЭРСДЭЛИЙН ХАРИЛЦАА ХОЛБООНЫ УДИРДАМЖ

1. Эрүүл мэндийн яам /Үндэсний түвшин

- ДДУХ-ийн мэдээлэл харилцааны үндэсний стратегийг батлах
- Олон нийтэд зориулсан мэдээлэл харилцааны үйл ажиллагааны үед ил тод, хариуцлагатай байх зарчмыг баримтлах
- Холбогдох байгууллагуудтай нэн даруй мэдээлэл солилцох (эмийн агентлаг, ДДУХ шалтгаан хамаарлын хороо, улс төрчид, мэргэжлийн холбоод, ир сургуулиуд, эмнэлэг, үйлдвэрлэгчид, олон улсын байгууллагууд)
- ТВ, радио, сонин, болон бусад хэвлэл мэдээллийн байгууллагуудаар хэвлэлийн мэдээг түгээх, мэдэгдэл гаргах
- ДДУХ-ийн олон тохиолдол бүртгэгдсэн бол үндэсний хэмжээний хэвлэлийн хурал зохион байгуулах
- Үндэсний болон олон улсын хэвлэл мэдээллийн байгууллагуудаар тараагдаж байгаа мэдээлэлд сониторинг хийж, шаардлагатай бол буруу ташаа мэдээллийг залруулах
- Хэвлэл мэдээллийн байгууллагад шинэчлэгдсэн мэдээллийг тогтмол өгөх, мэдээллийн багц бэлтгэх (түгээмэл асуултын хариулт, факт шийт гэх мэт)
- Эрүүл мэндийн чиглэлээр ажилладаг сэтгүүчдийг бэлтгэх
- Инфодемик менежментийн үйл ажиллагааг чиглүүлэх

2. Аймаг, дүүргийн түвшин

- ЭМЯ болон аймаг дүүргийн мэдээлэл харилцааны үйл ажиллагааг зохицуулах
- Аймаг, дүүргийн холбогдох байгууллагууд болон эрүүл мэндийн салбарынхныг баримт нотолгоотой мэдээллээр хангах
- Эрүүл мэндийн салбар мэргэжилтнүүдийг сургаж чадавхижуулах
- Аймаг, дүүрэг орон нутгийн хэмжээнд тарах мэдээ мэдээллийн үнэн зөв байдалд анхаарч зөрүүтэй мэдээлэл тарахаас сэргийлэх
- Аймаг, дүүргийн хэмжээнд нөхцөл байдлын мэдээлэл хүн амд өгөх мэргэжилтнийг томилох

- Хэвлэл мэдээллээр тарж буй мэдээлэлд тандалт хийж, буруу ташаа мэдээлэлд хариу арга хэмжээ авах

3. Аймаг, дүүргийн дархлаажуулалт хариуцсан мэргэжилтэн

- Хэвлэл мэдээллийн байгууллага, олон нийтэд мэдээлэл түгээх эхний эрх бүхий хүн байна
- Аймаг, дүүргийн түвшинд ДДУХ-ийн асуудлаар олон нийтэд мэдээлэл өгнө
- ДДУХ бүртгэгдвэл нэн даруй ХӨСҮТ, ЭМЯ-тай холбогдож мэдээлнэ
- Эцэг эх, асран хамгаалагч, олон нийтэд баримт нотолгоотой мэдээллийг өгөх
- Вакцины аюулгүй байдал, авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар олон нийтэд мэдээллийг өгөх
- Орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллага, олон нийтэд зориулсан түгээмэд асуултын хариулт, мэдээ мэдээллийг бэлтгэх
- Орон нутгийн байгууллагуудын удирдлага, олон нийтийн төлөөллүүдтэй уулзалт зохион байгуулах
- Орон нутгийн хүн амын дунд тархаад байгаа буруу ташаа мэдээллийг залруулах
- Бүх түвшний дархлаажуулалтын асуудал хариуцсан мэргэжилтнүүдэд ДДУХ судалгааны үр дүнг мэдээлэх

4. Эрүүл мэндийн байгууллага/ эрүүл мэндийн ажилтнууд

- Үйлчлүүлэгч, эцэг эх, өвчтөнийг анхааралтай сонсох
- Худлаа амлалт өгөхгүйгээр үйлчлүүлэгчид ойлгуулах, тавьшруулах
- Эмнэлгийн тусламж үйлчилгээ авахад нь туслах
- Эцэг эх, асран хамгаалагчдад нөхцөл байдлын талаар тогтмол мэдээлэл хүргэх
- Үйлчлүүлэгчдэд дархлаажуулалтын дараа илэрч болох урвалын талаар мэдээлэх, ямар арга хэмжээ авах талаар тайлбарлах
- ДДУХ-ийн мэдээллийг дарах, нуухаас зайлсхийх; цуурхал үүсэхээс сэргийлэхийн тулд шуурхай мэдээлэх
- ДДУХ судалгааны үр дүнг эмч мэргэжилтнүүдэд хуваалцах, тэдэнд вакцины чанар авуулгүй байдлын талаар тайлбарлах
- Тухайн эрүүл мэндийн ажилтныг буруушаахгүй байх, алдааг засах арга хэмжээн дээр төвлөрөх

5. Хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллах (Бүх түвшинд)

- 6"W"-д хариулах байдлаар хэвлэлийн мэдээ бэлтгэх (Хэн, Юу, Хэзээ, Хаана, Яагаад, энэ үйл явдал дахиад гарах уу?)
- Хэвлэлд мэдээлэл өгч байгаа хүний ярьсан зүйлийн талаарх нарийн мэдээлэл хэвлэлийн мэдээнд орсон эсэхийг нягтлах
- Хэвлэлийн багцыг хэвлэлийн хурлын үеэр тараах (хэвлэлийн мэдээ, түгээмэл асуултын хариулт).
- Тогтсон өдрүүдэд хэвлэл мэдээллийн байгууллагы шинэчилсэн мэдээлээр хангах
- Хариулаагүй асуултад дараа нь заавал хариулах
- Олон нийтийн санаа бодлыг тандах тандалтыг тогтмол хийх

6. Олон нийт ба холбогдох байгууллагууд

- Холбогдох гол лидерүүд, удирдагч нартай уулзах (улс төрчид, шашны тэргүүнүүд гэх мэт).
- Олон нийттэй уулзах уулзалтыг зохион байгуулах
- Хямрал гарахаас өмнө олон нийтийн итгэлийг олох, харилцаа холбоо тогтоох
- Вакцинжуулалтын талаар ойлгомжтой, эерэг мессежийг тууштайгаар өгөх

7. Буруу ташаа мэдээлэл, инфодемик менежмент

- Буруу ташаа мэдээлэл, цуурхалд шуурхай хариу арга хэмжээ авах; хэрэв орон нутгийн түвшинд хянах боломжгүй бол дээд шатны удирдлагад мэдэгдэж, дамжуулах
- Цуурхал, буруу ташаа мэдээлэлд дүн шинжилгээ хийж, хариу арга хэмжээ авахад бэлтгэх
- Цаашид буруу ташаа мэдээлэл тарахаас сэргийлэх үйл ажиллагааны стратеги боловсруулах
- Инфодемик менежментийн үйл ажиллагаануудыг хэрэгжүүлэх:
 - Олон нийтийн санаа бодлыг сонсох
 - Эрдэмтэд, эмч мэргэжилтнүүдийн зөвлөмжийг олон нийтэд түгээх
 - Худал, ташаа мэдээлэлд тэсвэртэй байдлыг бий болгох

Эрүүл мэндийн сайдын 2026
оны дүгээр сарын өдрийн
-р тушаалын тавдугаар хавсралт

ДАРХЛААЖУУЛАЛТЫН ДАРААХ УРВАЛ, ХҮНДРЭЛИЙН БҮРТГЭЛИЙН ХУУДАС

/аймаг, хот, сум, дүүрэг/				Байгууллагын нэр /өрх, сум, тосгоны ЭМТ г.м/					20 оны сар					
№	Овог, нэр	Хаяг	Төрсөн он сар өдөр / нас	Дархлаажуулалт хийсэн он, сар, өдөр, цаг, минут	Хариу урвалын хэлбэр (код) [1] Хөнгөн [2] Хүнд /Ноцтой	Үр дүн (Эдгэж байгаа/ Эдгэрсэн / тахир дутуу / эдгээгүй/ Нас барсан)	Сэжиглэж буй вакцин (нэр, тун)	Цувралын дугаар	Уусгагчийн цувралын дугаар	Шинж тэмдэг эхэлсэн хугацаа (он, сар, өдөр, цаг, минут)	Мэдээлсэн он, сар, өдөр, цаг, минут	Судалгаа хийсэн (он, сар, өдөр)	Эцсийн онош	Шалтгаан (код)

Дархлаажуулалтын дараах урвал, хүндрэлийн (ДДУХ) мэдээллийг бүртгэх, мэдээллийн санд оруулах болон дүн шинжилгээ хийх үйл явцыг хөнгөвчлөх зорилгоор **бүсийн код, урвалын төрөл, ДДУХ-ийн шалтгаан, шалтгааны баталгаажлын түвшний кодчиллыг** хэрэглэнэ. Кодчлолын явцад алдаа гарахаас сэргийлж бүртгэгдсэн кодыг **давхар шалгаж баталгаажуулна.**

[A1] Вакцинтай холбоотой	[A2] Хөтөлбөрийн алдаа	[A3] Сэтгэл зүй, айдсаас үүдэлтэй	[B] Тодорхойлох боломжгүй	[C] Давхацсан	[D] Мэдээлэл хангалтгүй тул ангилах боломжгүй
-----------------------------	---------------------------	--------------------------------------	------------------------------	------------------	--

Эрүүл мэндийн сайдын 2026
оны дүгээр сарын өдрийн
.....-р тушаалын зургаадугаар хавсралт

ДДУХ-ИЙН СУДАЛГААНЫ ХУУДАС

Зөвхөн ноцтой хүнд ДДУХ (Нас барсан, тахир дутуу болсон, эмнэлэгт хэвтсэн, багц тохиолдол)

А хэсэг		Үндсэн мэдээлэл			
Аймаг	Дүүрэг	Тохиолдлын дугаар (ID)			
Вакцин хийсэн газар (□):		<input type="checkbox"/> Улсын байгууллага	<input type="checkbox"/> Хувийн ЭМБ	<input type="checkbox"/> Бусад _____	
Вакцинжуулалтын хэлбэр (□):		<input type="checkbox"/> Компанит	<input type="checkbox"/> Товлол	<input type="checkbox"/> Бусад _____	
Вакцин хийсэн нэгжийн хаяг:					
Мэдээлсэн хүний нэр: _____ Судалгаа хийсэн он сар өдөр: __ / __ / _____					
Судалгааны хуудас бөглөсөн он сар өдөр: ___ / ___ / _____					
Албан тушаал:		Энэ тайлан: <input type="checkbox"/> Эхний <input type="checkbox"/> Явцын <input type="checkbox"/> Эцсийн			
Утас (Ажлын):		Гар утас:		имэйл хаяг:	
Өвчтөний нэр _____ Хүйс: <input type="checkbox"/> Эр <input type="checkbox"/> Эм					
(Багц тохиолдол бол тус тусад нь бөглөх)					
Төрсөн он сар өдөр: _____ / _____ / _____					
Эсвэл шинж тэмдэг эхлэх үеийн нас: _____ жил _____ сар _____ өдөр Эсвэл насны бүлэгээр: <input type="checkbox"/> <1 нас <input type="checkbox"/> 1-5 нас <input type="checkbox"/> >5 нас					
Өвчтөний гэрийн хаяг дэлгэрэнгүй байдлаар (дүүрэг, хороо, гудамж, орон сууц, хашаа байшин/хаалганы дугаар, утасны дугаар гэх мэт):					
Өвчтөний хийлгэсэн вакцин болон уусгагчийн нэр	Вакцин хийлгэсэн он сар өдөр	Вакцин хийсэн цаг	Хэд дэх тун (1 дэх, 2 дахь гэх мэт)	Цуврал багцын дугаар	Дуусах хугацаа
				Вакцин	Вакцин
				Шингэлэгч	Шингэлэгч
				Вакцин	Вакцин
				Шингэлэгч	Шингэлэгч
				Вакцин	Вакцин
				Шингэлэгч	Шингэлэгч
				Вакцин	Вакцин
				Шингэлэгч	Шингэлэгч
				Вакцин	Вакцин
				Шингэлэгч	Шингэлэгч

Нэгжийн хэлбэр Байнгын Явуулын Түр Бусад _____

Эхний шинж тэмдэг эхэлсэн он сар өдөр: _____ / _____ / _____ Эхэлсэн цаг/минут: _____ / _____

Эмнэлэгт хэвтсэн он сар өдөр: _____ / _____ / _____

Анх эрүүл мэндийн байгууллагад хандсан он сар өдөр: _____ / _____ / _____

Судалгаа хийх үеийн нөхцөл байдал Нас барсан Тахир дутуу Эдгэрч байгаа Бүрэн эдгэрсэн Мэдэхгүй

Хэрэв нас барсан бол он сар өдөр: _____ / _____ (цаг/мин) _____ / _____

Задлан шинжилгээ хийсэн эсэх (он сар өдөр) _____ Үгүй Төлөвлөж буй цаг хугацаа, он сар өдөр _____ цаг _____ тайланг хавсаргах (хэрэв боломжтой бол)

Б хэсэг **Вакцинаас өмнөх үеийн өвчтөний талаарх мэдээлэл**

Асуулт	Хариулт	Хэрэв тийм гэсэн бол дэлгэрэнгүй мэдээлэл бичих
Өнгөрсөн хугацаанд ижил төстэй үйл явдал тохиолдсон эсэх	Тийм/Үгүй/Мэдэхгүй	
Өмнөх вакцинжуулалт (ууд)-ын үед хариу урвал илэрч байсан эсэх	Тийм/Үгүй/Мэдэхгүй	
Вакцин, эм, хүнсний харшилтай эсэх	Тийм/Үгүй/Мэдэхгүй	
Вакцин хийлгэхээс өмнөх 30 хоногийн хугацаанд ямар нэг өвчин эмгэг, зовирутай байсан эсэх/төрөлхийн өвчин эмгэг байсан эсэх	Тийм/Үгүй/Мэдэхгүй	
Сүүлийн 30 хоногт эмнэлэгт хэвтсэн эсэх	Тийм/Үгүй/Мэдэхгүй	
Өвчтөн вакцин хийлгэх үед эм тариа хэрэглэж байсан эсэх? (Хэрэв тийм бол эм тарианы нэр, хэрэглэх болсон шалтгаан, тун хэмжээ, эм тариа хэрэглэсэн хугацаа)	Тийм/Үгүй/Мэдэхгүй	
Гэр бүлийн хэн нэгэн ДДУХ-тэй холбоотой өвчин эмгэгээр өвдөж байсан эсэх, эсвэл харшилтай эсэх	Тийм/Үгүй/Мэдэхгүй	
Нөхөн үржихүйн насны эмэгтэй хүн бол <ul style="list-style-type: none"> Жирэмсэн эсэх? Тийм бол хэдэн 7 хоногтой _____ / Үгүй / Мэдэхгүй Хөхүүл эсэх? Тийм/Үгүй 		
Бага насны хүүхэд бол Хүүхэд төрөхдөө <input type="checkbox"/> Хугацаандаа бүрэн <input type="checkbox"/> Хугацаанаасаа өмнө <input type="checkbox"/> Хугацаанаасаа хойш. Төрөх үеийн жин: _____		
Төрөлтийн хэлбэр <input type="checkbox"/> Хэвийн <input type="checkbox"/> Ксераво <input type="checkbox"/> Багажийн тусламжтай <input type="checkbox"/> Хүндрэлтэй (тодорхойл)		

В хэсэг Ноцтой ДДУХ-ийн эхний үзлэгийн талаарх нарийвчилсан мэдээлэл		
Мэдээллийн эх сурвалж(✓ тохирох бүгдийг сонго) <input type="checkbox"/> Судлаачийн судалгаа <input type="checkbox"/> Бичиг баримт <input type="checkbox"/> Аман мэдээлэл <input type="checkbox"/> бусад _____ Хэрэв аман мэдээлэл бол мэдээллийн эх сурвалж _____		
Эхний үзсэн/ эмчилсэн хүний нэр: _____ Өвчтөнийг эмчилж буй бусад хүний нэрс: _____ Мэдээлэл өгсөн бусад эх сурвалж: _____		
Вакцин хийлгэсэн цаг хугацаанаас эхлээд илэрсэн шинж тэмдгийг цаг хугацааны дарааллаар тэмдэглэх:		
Эмнэлзүйн мэдээллийг бөглөсөн хүний нэр, холбоо барих мэдээлэл:	Албан тушаал:	Он, сар, өдөр, цаг:
<p>**Заавар – Бүх бэлэн байгаа бичиг баримтыг хавсаргана (өвчтөний түүх, өвчтөн гарах үеийн товч мэдээлэл, лабораторийн үр дүн, задлан шинжилгээний тайлан). Мөн бусад хавсрагдаагүй бичиг баримтын мэдээллийг оруулах.</p> <ul style="list-style-type: none"> • Хэрэв өвчтөн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авсан бол <input type="checkbox"/> <u>бүх бэлэн байгаа бичиг баримтын хуулбарыг хавсаргах</u> (өвчтөний түүх, эмнэлгээс гарах үеийн товч мэдээлэл, лабораторийн тайлан, задлангийн тайлан) <u>мөн бичиг баримт нь бэлэн биш байгаа бол мэдээллийг бичих</u> • Хэрэв өвчтөн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ аваагүй бол – түүхийн талаарх мэдээллийг олох, үзлэг хийж мэдээллийг бичих (шаардалгатай бол нэмэлт хуудас ашигла) 		
Урьдчилсан / Эцсийн онош:		

Г хэсэг Тухайн өдөр ДДУХ-тай холбоотой вакциныг хийлгэсэн тухай дэлгэрэнгүй										
Тухайн вакцин хүүхдийн вакцин гаргах. (Тайланг авсаргах)	нэгжид хийлгэсэн тоог болгоноор (Тайланг авсаргах)	Вакцины нэр								
		Хэдэн тун тарьсан								
1) Өвчтөн хэзээ вакцин хийлгэсэн бэ? (<input type="checkbox"/> доорх мэдээллийг уншаад бүх асуултад хариулна уу)										
<input type="checkbox"/> Вакцинжуулалтын эхний үед <input type="checkbox"/> Вакцинжуулалтын төгсгөлд <input type="checkbox"/> Мэдэхгүй										
Олон хүн тунтай бол <input type="checkbox"/> эхний хэдэн тунг хийх үед <input type="checkbox"/> сүүлийн хэдэн тун хийлгэх үед вакцин хийлгэсэн <input type="checkbox"/> мэдэхгүй <input type="checkbox"/>										
2) Энэхүү вакциныг зааврын дагуу зааж өгөхөд алдаа гарсан эсвэл зөвлөмжийг дагаагүй тохиолдол бий юу?										Тийм / Үгүй
3) Судалгаан дээр үндэслээд тарьсан вакцин эсвэл уусгагч шингэн ариун биш байсан байна уу?										Тийм / Үгүй / Үнэлэх боломжгүй
4) Судлаад үзэхэд вакцины гаднах байдал (өнгө, гадны биетээр бохирдох) гэх мэтээр вакцин тарих үед хэвийн бус байсан байна уу?										Тийм / Үгүй / Үнэлэх боломжгүй
5) Судлаад үзэхэд вакцин найруулах үед эсвэл вакцин бэлтгэх үед алдаа гарсан байна уу? (буруу вакцин, буруу уусгагч, буруу холих, тариураар буруу соруулсан гэх мэт)?										Тийм / Үгүй / Үнэлэх боломжгүй
6) Вакциныг хадгалах, тээвэрлэх үед алдаа гарсан байна уу? (тээвэрлэх үед, хадгалах эсвэл тарих үед хүйтэн хэлхээнд алдаа гарсан)										Тийм / Үгүй / Үнэлэх боломжгүй
7) Вакциныг тарих үед буруу тарьсан байна уу (буруу тун, тарих талбайг буруу сонгосон, буруу техникээр тарьсан, буруу зүү сонгосон, аюулгүй тарилгын практикийг дагаж мөрдөөгүй)?										Тийм / Үгүй / Үнэлэх боломжгүй
8) Сэжиглэж байгаа вакциныг хэдэн хүнд тарьсан байна бэ?										
9) Тухайн өдөр сэжиглэж байгаа вакцинаар хэдэн хүнийг тарьсан байна вэ?										
10) бусад байршилд ижил цувралын дугаартай вакцинаар хэдэн хүнийг дархлаажуулсан байна вэ? Байршлыг тодруул: _____										
11) Багц тохиолдлын нэг нь үү?										Тийм / Үгүй / мэдэхгүй
12) Хэрэв тийм бол, багцад нийт хэдэн тохиолдол байна вэ?										
а. Бүх тохиолдол нэг ижил флаконоос вакцин хийлгэсэн байна уу?										Тийм / Үгүй / мэдэхгүй
б. Үгүй бол, багцыг тохиолдлыг вакцинжуулахад хэдэн флакон вакцин хэрэглэсэн байна вэ? (дэлгэрэнгүй мэдээллийг тусад нь оруул)										

Эдгээр хариултад тусдаа тайлбар хэрэгтэй

Д хэсэг. Сэжиглэж буй вакциныг хэрэглэсэн газрын дархлаажуулалтын дадал (Асуух эсвэл ажиглах байдлаар бөглөнө)

Хэрэглэсэн зүү, тариур:

- Өөрөө эвдэрдэг зүү тариур хэрэглэсэн үү? Тийм / Үгүй / мэдэхгүй
- Хэрэв үгүй бол, хэрэглэсэн зүү тариурын хэлбэр: Шилэн Өөрөө эвдэрдэг Дахин боловсруулсан нэг удаагийн Бусад _____

Гол ажиглалт, нэмэлт ажиглалт, тайлбар:

Найруулах:

- Найруулах үйл ажиллагаа

Ижил вакцины олон флаконд ижил найруулдаг тариур хэрэглэсэн үү?	Тийм	Үгүй	хамаарахгүй
Өөр өөр вакциныг найруулахад ижил тариур ашигласан уу?	Тийм	Үгүй	хамаарахгүй
Вакцины флакон болгонд тусдаа найруулдаг тариур ашигласан уу?	Тийм	Үгүй	хамаарахгүй
Вакцин болгонд тусдаа найруулдаг тариур ашигласан уу?	Тийм	Үгүй	хамаарахгүй
- Үйлдвэрлэгчийн зааврын дагуу вакцин болон уусгагчид ижил тариур хэрэглэсэн үү? Тийм / Үгүй / хамаарахгүй

Гол ажиглалт, нэмэлт ажиглалт, тайлбар:

**ДАРХЛААЖУУЛАЛТЫН ДАРААХ УРВАЛ, ХҮНДРЭЛИЙН ҮЕД
ЛАБОРАТОРИЙН ШИНЖИЛГЭЭНД СОРЬЦ АВАХ ЗААВАР**

ДДУХ-ийг лабораториор баталгаажуулах, эсвэл үгүйсгэхийн тулд шаардлагатай сорьцыг цуглуулан шинжилгээнд илгээх шаардлагатай. ДДУХ-ийн шалтгааны талаарх таамаглал ямар байхаас шалтгаалан сорьцыг сонгоно.

Өвчтөнөөс авах сорьц

- Цус, шээс, тархи нугасны шингэн , шарх /буглаанаас авсан арчдас/
- Өвчтөн нас барсан тохиолдолд задлан шинжилгээний сорьц, гистологийн шинжилгээнд зориулан эдийн сорьц авна.

Дархлаажуулалтын нэгжид хэрэглэж буй вакцинаас авах сорьц

- ДДУХ илэрсэн хүүхдүүдэд хэрэглэсэн вакцины үлдэгдэл
- Сэжиглэж байгаа вакцинтай нэг хөргөгчид хадгалагдаж байсан задлаагүй, ижил төрлийн вакцин болон найруулах уусмалаас төлөөлүүлэн доорх байдлаар шинжилгээнд авна.
 - Тухайн эрүүл мэндийн байгууллагаас – 2 флакон
 - Төв агуулахаас 5 флаконыг тус тус авна.
- Зүү, тариураас сорьц авах.
 - Ихэвчлэн тухайн тохиолдолд хэрэглэсэн зүү, тариур нэг удаагийн аюулгүйн хайрцагт хийж устгадаг тул шинжилгээнд авах боломжгүй байдаг. Иймээс тухайн дархлаажуулалтад хэрэглэсэнтэй ижил задлаагүй шинэ зүү, тариурыг шинжилгээнд авна.

ДДУХ-ийн үед илэрсэн шинж тэмдэг, хэлбэрээс шалтгаалан дараах сорьцыг шинжилгээнд авна:

Урвал, хүндрэлийн хэлбэр	Өвчтөнөөс авах сорьц	Вакцин, уусгагч, зүү тариур
Хэсэг газрын хариу урвал: - Буглаа - Лимфоаденит	- Арчдас, цус - Цус	Вакцин, уусгагч
Төв мэдрэлийн тогтолцоонд илрэх урвал хүндрэл: ТМТ-ны шинжүүд - Саажилтгүй - Саажилттай	- Тархи нугасны шингэн, цус • Өтгөн	Вакцин, уусгагч

Бусад: - Анафилакси - Хордлогын шок - Нас барсан	Цус, цусны өсгөвөр, задлангийн эдийн шинжилгээ	Вакцин, уусгагч, зүү, тариур
---	--	------------------------------------

Сорьц илгээхэд анхаарах зүйлс

- Бүх сорьцыг (өвчтөнөөс авсан болон вакцин, найруулах уусмал, зүү тариур) зориулалтын сав, полиэтилен уутанд хийж, битүүмжлэн, шошго наана.
- Шингэн агууламж бүхий сорьцыг дээш харуулж байрлуулна.
- Төв лабораторид илгээхдээ мөстэй орчинд тээвэрлэнэ.
- Сорьцыг шинжилгээний дагалдах хуудсын хамт илгээнэ.

ДАРХЛААЖУУЛАЛТЫН ДАРААХ УРВАЛ, ХҮНДРЭЛИЙН ЛАБОРАТОРИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ДАГАЛДАХ ХУУДАС №

Өвчтөний овог нэр:.....
Төрсөн:он.....сар.....өдөр
Нас:..... Хүйс:.....
Хаяг:.....
ДДУХ-ийн шинж тэмдэг илэрсэнон.....сар.....өдөр
Сорьц авсан:он.....сар.....өдөр
Сорьц илгээсэн:он.....сар.....өдөр
Сорьцын дэлгэрэнгүй мэдээлэл (Цус, ТНШ, өтгөн, зүү тариур, вакцин гэх мэт)
Сорьцыг тээвэрлэсэн нөхцөл: <input type="checkbox"/> Хуурай мөс <input checked="" type="checkbox"/> тэмдэглэнэ <input type="checkbox"/> Мөстэй сав <input type="checkbox"/> Бусад
Хийлгэх шинжилгээний нэр:
Эмнэл зүйн урьдчилсан онош:
Шинжилгээ явуулсан хүний нэр, албан тушаал:
Хаяг:
Утасны дугаар:
Сорьц хүлээн авсан:он.....сар.....өдөр
Хүлээн авсан хүний нэр.....
Хүлээн авсан сорьцны байдал: <input type="checkbox"/> Сайн <input checked="" type="checkbox"/> тэмдэглэнэ <input type="checkbox"/> Муу
Шинжилгээний Хариу:
Шинжилгээний хариу өгсөн:он.....сар.....өдөр
Шинжилсэн эмчийн нэр:
Утасны дугаар:
Шинжилгээ хийсэн байгууллагын нэр: